



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Цэвэр хот” орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/8/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: О.Алтансүх Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Орлого зарлагын талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г "ЦЭВЭР ХОТ" ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ЗАХИРАЛ
Ц.БАЯСГАЛАН ТАНАА

2020.02.27 № 265
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

• 005020217

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.1. Оршил

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ц.Баясгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгад дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.27-наас 2020.03.03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.03.11-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.02.10-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК нь "Баянхонгор сумын нийт нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлыг нэгдсэн төв цэгт төвлөрүүлэх аж ахуйн нэгж, иргэдийн хог хаягдлыг стандартын дагуу тээвэрлэх цэвэр орчин бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх." гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Байгууллагын удирдлагын хувьд дараах хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус *Цэвэр хот* орон нутгийн өмчит ХХК-ын хувьд Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж гаргаагүй байна.

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тоцоолох группын нягтлан бодох бүртгэлийн Leader 3 санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар ***Цэвэр хот*** орон нутгийн өмчит ХХК-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 28 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд,” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 643046,6 мянган төгрөгөөс тооцон 12860,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 150283,4 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Банкинд байгаа үлдэгдэл	338,5	18,8	319,7
Авлага	2534,5	2534,5	0

Бараа материал	18867,3	21837,8	2970,4
Үндсэн хөрөнгө	159246,9	125892,2	-33236,7
Нийт хөрөнгө	180987,4	150283,4	-30703,9
Өр төлбөр	49687,8	19287,5	-30400,2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	131299,5	130995,8	303,6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	180987,4	150283,4	-30703,9

Тайлант оны харилцах дансны эцсийн үлдэгдэл 18,8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 319,7 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага оны эцэст 2534,5 мянган төгрөг байгаа нь хувь хүнээс авах авлага болон өмнөх онуудад НӨАТ-ын тайлан гаргаж баримт хэвлэж өгдөг байснаас шалтгаалж үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2970,4 мянган төгрөгөөр өссөн нь Баян-ойт бага сургуулиас 2800,0 мянган төгрөгийн үнэтэй түлшний модыг үнэгүй шилжүүлж авсан, мөн сэлбэг хэрэгслийн материал авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 33236,7 мянган төгрөгөөр буурсан нь 480,0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, Баянхонгор аймгийн ИТХТ-ийн 2019.12.25-ны өдрийн 122 тогтоолоор 88494,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данс бүртгэлд орлогод авсан, мөн тайлант оны элэгдлийн зардал 251002,8 мянган төгрөгөөр тооцож зардалд бүртгэж цэвэр дүнгээр илэрхийлснээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 869,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 130995,8 мянган төгрөг болж өмнөх оноос 303,6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

2.10. Орлого зарлагын талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, гүйцэтгэх захирал нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын тайлант онд нийт үйл ажиллагааны мөнгөн орлого 551567,0 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 551886,7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд шилжүүлж, 18,8 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн ИТХТ-ын 2019.12.25-ны 134 тогтоолоор 2020 оноос Баянхонгор аймгийн цэвэр хот Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нэртэйгээр Хог тээвэрлэлийн үйл ажиллагаа, Нийтийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, Нийтийн гудамж талбайд хогийн сав байршуулах, ашиглах үйлчилгээ гэсэн үйл ажиллагааны чиглэлийг баримтлан ажиллаж байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 28 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3913,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллээс хугацаанд нь 124 мэдээллийг, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	10	10	9	1		
2	Хагас жил	1	3	3			
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	33	3		
5	Тухай бүр	7	84	76	8		
	Нийт	22	137	124	13		

2019 оны тайлант онд Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт мэдээний бүтэн жил, 1-р улирал, 5 дугаар сар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл мэдээний 5 дугаар сар, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт мэдээний 5 дугаар сар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 12 дугаар сар, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт мэдээний 12 дугаар сар, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн мэдээний 12 дугаар сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг мэдээний 12

дугаар сар, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээний 11, 12 дугаар сар, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээний 12 дугаар сар, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн 12 дугаар сарын мэдээнүүдийг тус тус хугацаа хоцроосон байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Байхгүй

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид *Цэвэр хот* орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Цэвэр хот орон нутгийн өмчит ХХК-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журмууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Цэвэр хот" орон нутгийн өмчит ХХК-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд ус байгууллага нь НББ-ын хууль, стандарт журам зааварт нийцүүлэн өөрийн байгууллагын НБББББ-ыг боловсруулан гаргаж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл:

Тайлан үнэн зөв гаргах

1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт, 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг мөрдөж НБББББ-г боловсруулан захирлаар баталгаажуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

1.5. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст Нийгмийн даатгалын хэлтэст 3913,8 мянган төгрөгийн өртэй гарсан нь НДШ-ын суутгалыг цаг хугацаанд шилжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Энэ нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна

1.6. Өгсөн зөвлөмж:

Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос суутгасан болон ажил олгогчийн даатгуулагчийн шимтгэлийн тооцоог цаг тухайд шилжүүлэн Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх хуулийг хэрэгжүүлж ажиллан өглөгийг барагдуулах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	338,517.42	18,800.20
1.1.2	Дансны авлага	1,080,000.00	1,080,000.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	1,454,590.16	1,454,590.16
1.1.6	Бараа материал	18,867,330.00	21,837,817.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	21,740,437.58	24,391,207.36
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	159,128,972.43	125,892,260.78
1.2.1	Үндсэн хөрөнгө	159,128,972.43	125,892,260.78
1.2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	159,246,972.43	125,892,260.78
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	180,987,410.01	150,283,468.14
2.1.1.1	Дансны өглөг	12,184,266.82	15,373,742.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	33,603,265.79	3,913,857.70
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	49,687,872.51	19,287,599.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	49,687,872.51	19,287,599.70
2.3.1	Өмч: - төрийн	401,066,447.00	489,560,447.00
2.3.10	Тайлант үеийн хуримтлагдсан ашиг	0.00	(88,797,669.06)
2.3.11	тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	(269,766,909.50)	(269,766,909.50)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	131,299,537.50	130,995,868.44
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	180,987,410.01	150,283,468.14

3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	369,455,563.88	554,249,017.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	288,650.00	2,000.00
3	Нийт ашиг (алдагдал)	369,166,913.88	554,247,017.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	139,969,334.89	232,581,510.27
10	Ерөнхий ба удирдлагын зардал	108,938,461.82	160,007,352.00
11	Санхүүгийн зардал	231,257,197.00	248,627,364.79
12	Бусад зардал	4,347,025.00	1,830,459.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(115,345,104.83)	(88,797,669.06)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(115,345,104.83)	(88,797,669.06)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(115,345,104.83)	(88,797,669.06)
24	Орлогын нийт дүн	(115,345,104.83)	(88,797,669.06)

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	369266050.00	551,567,017.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	369266050.00	551,567,017.00

120	Нийтлэг татварын бус орлого	369266050.00	551,567,017.00
120009	Бусад орлого	17581050.00	3,000,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	343935000.00	523,441,400.00
120015	татаас, Санхүүжилтын орлого /ТӨҮГ/	7750000.00	25,125,617.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	371981070.40	551,406,734.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	371981070.40	551,406,734.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371981070.40	551,406,734.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191820998.00	220,797,227.38
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	191820998.00	220,797,227.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23000000.00	100,137,955.23
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	23000000.00	100,137,955.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1844881.00	5,386,269.82
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	1844881.00	5,386,269.82
2104	Хангамж, бараа материалын зардал	121048022.00	179,936,611.01
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	104449672.00	144,512,100.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	16598350.00	35,424,511.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34267169.40	45,148,670.78
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	12924506.40	19,271,474.78
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	20478838.00	25,877,196.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-2715020.40	160,282.78
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	480,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	480,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	480,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		480,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	(480,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-2715020.40	(319,717.22)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3053537.82	338,517.42
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	338517.42	18,800.20

3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2018 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	383,846,398.00	(154,421,804.67)	229,424,593.33
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,220,049.00	(115,345,104.83)	(98,125,055.83)
2019 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	401,066,447.00	(269,766,909.50)	131,299,537.50
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	88,494,000.00	(88,797,669.06)	(303,669.06)
2019 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	489,560,447.00	(358,564,578.56)	130,995,868.44

Аудитын тайланг

Хянанс:

Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат 2018.02.27

Аудитын менежер А.Цээням 2018.02.27

Бэлтгэсэн:

Аудитор О.Алтансүх 2018.02.27